

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН 2018 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 03 дугаар сарын 29

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. “НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийслэл хэрэгжүүлэхээр тусгасан 209 арга хэмжээнээс нийслэлийн Өмчийн харилцааны газарт хамаарах 3 ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тооцон ажиллаж байна.

5.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.

- ✓ Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийх, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах, шинээр хөрөнгө худалдан авах асуудлыг оновчтой шийдвэрлэж, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх
- ✓ Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, төрөл, нормативыг тогтоох, хяналт тавих замаар төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авах
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийн системийг боловсронгуй болгох

1.2 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 1 зорилтын хүрээнд Өмчийн харилцааны газар нь үндсэн чиг үүргийнхээ дагуу Эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 4 ажлын хэрэгжилтийг ханган ажиллахаар, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

1.6.1 Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг өгөөжийг нэмэгдүүлнэ.

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын худалдан авалтын төлөвлөгөөг ил тод болгон худалдан авалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж /хяналтыг сайжруулан/ тэвчиж болох худалдан авалт, удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулан төсвийн зардлыг хэмнэх:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/45 дугаар захирамжаар Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах Контрактын төсөл, 2018 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төслийг бэлтгэх үүрэг бүхий “Ажлын хэсэг” байгуулан, 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд орон нутгийн өмчит 32 үйлдвэрийн газруудын 2018 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтот түвшний төслийг хэлэлцүүлэн НЗД-ын Зөвлөлийн хуралд 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр танилцуулж, НЗД-ын 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/259 дүгээр захирамжаар батлуулсан.

"Эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх 2018 оны зорилтод 32 үйлдвэрийн газар 244.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх санал ирүүлснийг хянаж 244.9 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө дэвшүүлсэн ба энэ нь 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 4,2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн.

Түүнчлэн 32 үйлдвэрийн газар 277.7 тэрбум төгрөгийн зардал гаргах санал оруулсныг 3.7 тэрбум төгрөг болгон хэмнэн 274.0 тэрбум төгрөгийн зардлын төлөвлөгөө дэвшүүлэн батлуулсан.

1.2.2 Улаанбаатар хотын дүүрэг бүрд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих борлуулалтын нэгдсэн төвийг барьж “Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Дүүргүүдийн ОНӨҮГ-үүдэн эрх зүйн орчинг боловсронгуй болгож үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх асуудлыг судлан хэрэгжүүлж эхэлнэ.

Дүүргүүдийн ОНӨҮГ-уудын 2017 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлан гарч дуусаагүй байгаа бөгөөд дүүргүүдийн ОНӨҮГ-уудын судалгаа хийгдэж байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээний аргачлалын төслийг боловсруулж хэрэгжүүлнэ.

Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийг үнэлэх, нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ.

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах, орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг 2018 онд зохион байгуулахтай холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2018 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд “Хөрөнгийн дахин үнэлгээний бэлтгэл, 2017 оны улсын нэгтгэлд анхаарах асуудлууд”, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системийн танилцуулга” сургалтыг зохион байгуулж хариуцсан мэргэжилтнүүд хамрагдсан.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх бэлтгэл ажлыг хангах тухай зөвлөмжийг 9 дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэст 2018 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 3/223-3/232 тоот албан бичгүүдээр хүргүүлэв.

4.1.9 "Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний загвар" төсөл хэрэгжүүлж, "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, эрүүл, баталгаат хоол хүнс хэрэглэх нөхцөл бүрдүүлнэ.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

"Сургууль, цэцэрлэгийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний нийтлэг шаардлага" боловсруулж, "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах тогтолцоог бүрдүүлнэ:

Налайх дүүргийн "Хангамж үйлчилгээний төв" ОНӨААТҮГ нь Тохижилт үйлчилгээний компанийн байранд түрээсээр үйл ажиллагаа явуулдаг байна. Дүүргийн удирдлагуудтай санал солилцон ЗДТГ-ын балансад бүртгэлтэй хуучнаар 1 дүгээр хорооны өрхийн эмнэлгийн байрыг өгөхөөр болсон боловч холбогдох материалыг ирүүлээгүй байна. Уг асуудал нь НИТХТ-ийн шийдвэрээр шийдвэрлэгдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ " ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН"

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2018 оны үндсэн чиглэлд нийслэлийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр манай байгууллагын хариуцан хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд бусад ажлуудыг дараах төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган биелэлтэд хяналт тавин ажиллалаа.

1. Байгууллагын үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө

2. НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

3. Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

4. Байгууллагын үйл ажиллагаанд байнга мөрдөж ажиллах заавар, журам, стандартыг хэрэгжүүлэх, 2018 оны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр шалган зааварлах ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө

*5. 2018 онд зохион байгуулагдах "Сургалтын төлөвлөгөө",
Мэдээллийн цагийн хуваарь*

6. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2018 оны төлөвлөгөө


7. Монгол Улсын Засгийн газрын "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгаарыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2017.10.26/

8. 2018 онд "Спорт хамтлаг"-ийн зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө

9. Авилгын эсрэг 2018 оны төлөвлөгөө

10. 2018 оны архивын ажлын төлөвлөгөө

2.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт



Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/86 дугаар захирамжаар батлагдсан “Иргэдийн оролцоотой –Амьдрах орчныг сайжруулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хүлээн авч үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлах, нийслэлээс хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгч, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах, хорооны үйл ажиллагааг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилтын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын хариуцан ажиллах хороод, удирдамжийг Нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/918 дугаар “Хуваарь батлах тухай” захирамжаар баталсан.

Тус захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 7 удирдах албан тушаалтан хариуцсан Баянгол дүүргийн 14, 15, 17, 18, 19, 20, 21, Хан-Уул дүүргийн 7 дугаар хороодод ажиллаж байна. Байгууллагын удирдлагууд уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн мэндчилгээг хорооны Засаг дарга нарт уламжлан, тус хороодод хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд болон цаашид анхаарах, хийж хэрэгжүүлэх ажлуудын талаар ярилцан санал солилцож, Нийслэлийн Засаг дарга, асуудал хариуцсан орлогч дарга нарт уламжлан ажиллаж байна. Хороодод ажилласан талаарх мэдээ тайланг цаг хугацаанд нь НЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлсэн.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Мөн Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/699 дүгээр “Шуурхай мэдээллийн үзүүлэлтийг батлах тухай” захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын 14 хоногийн тайлан мэдээ, ажлын төлөвлөгөөг НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан бичгээр болон monitoring@ulaanbaatar.mn цахим хаягаар тогтсон цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.

	Хурлын тоо	Үүрэг даагавар	Биелэлт
Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн	4 удаа	12	100%
Байгууллагын шуурхай зөвлөгөөн	7 удаа	93	76 – 100% 17– 50%

Байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлыг 5 удаа, Ёс зүйн хороог 1 удаа хуралдуулах үйл ажиллагааны бэлтгэлийг ханган, хурлын тэмдэглэлийг хөтөлж, баталгаажуулан ажилласан.

ГУРАВДУГААР БҮЛЭГ “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН” ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ:

Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулан, нийт 47 ажил үйлчилгээ, тусгай захиалгат 11 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.1.Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бүүруулна.



Нийслэлийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн “ Ажлын хэсэг байгуулах тухай” А/45 дугаар захирамжаар Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах Контрактын төсөл, 2018 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төслийг бэлтгэх үүрэг бүхий “Ажлын хэсэг” байгуулан, 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд орон нутгийн өмчит 32 үйлдвэрийн газруудын 2018 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

зорилтот түвшний төслийг хэлэлцүүлэн НЗД-ын 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд оруулж НЗД-ын А/259 дүгээр захирамжаар батлууллаа.

Үйлдвэрийн газруудын 2018 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтыг хэлэлцэхдээ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоол, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт үйлдвэрийн газруудын үр ашгийг дээшлүүлэхээр тусгасан заалтуудыг үндэслэн үйл ажиллагааны үр дүнг 2017 оны түвшингээс бууруулахгүй, үйл ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлэх, шинэ техник технологийг нэвтрүүлэхийг дэмжих, үндсэн үйл ажиллагаанаас гадна, бусад төрлийн орлого гол нь төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зайлшгүй гарах зардлаас бусад зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах боломжит арга замыг хэрэгжүүлэх зэрэг бодлого баримтлан ажиллаа.

Нийслэлд 2017 онд 33 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулснаас Усан спорт сургалтын төв ОНӨААТҮГ-ыг 2018 оны 01 дүгээр сард нээлттэй дуудлага худалдаагаар хувьчилж, 2018 онд 32 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулж байгаас 21 аж ахуйн тооцоот, 11 төсөвт үйлдвэрийн газар байна.

Нийт орлогын талаар:

2016 онд 33 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулж, 219.0 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 208.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн төлөвлөгөөг 95 хувь биелүүлсэн бөгөөд 2017 онд 241.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 240.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, төлөвлөгөө 99.5 хувийн биелэлттэй байна.

2018 онд нийт 32 үйлдвэрийн газраас 244.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх санал ирүүлснийг хянаж 244.9 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө дэвшүүлсэн ба энэ нь 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 4,2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн.

/мянган төгрөг/

№	Он	Үйлдвэрийн газруудын тоо	Зорилт	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Хувь
1	2016	33	218,954,903.0	208,024,177.0	10,930,726.0	95.01%
2	2017	33	241,751,372.1	240,610,651.9	1,140,720.2	99.53%
3	2018	32	244,883,437.6			

Нийт зардлын талаар:

2016 онд 33 үйлдвэрийн газар 234.9 тэрбум төгрөгийн зардал төлөвлөснөөс 254.7 тэрбум төгрөгийн зардал гарган ажиллаж зардлыг 4.9 хувь хэтрүүлсэн бол 2017 онд 271.2 тэрбум төгрөгийн зардал төлөвлөснөөс гүйцэтгэлээр 258.1 тэрбум төгрөгийн зардал гарган 0.47 хувь хэмнэсэн байна.

2018 онд 32 үйлдвэрийн газар 277.7 тэрбум төгрөгийн зардал гаргах санал оруулсныг 3.7 тэрбум төгрөг болгон хэмнэн 274.0 тэрбум төгрөг болгон төлөвлөгөө дэвшүүлсэн.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

/мянган төгрөг/

№	Он	Үйлдвэрийн газруудын тоо	Зорилт	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Хувь
1	2016	33	243,883,699.0	254,679,678.4	10,795,979.4	4.99%
2	2017	33	271,212,695.5	258,111,438.8	-13,101,256.7	0.47%
3	2018	32	273,959,909.4			

Цэвэр ашиг, алдагдлын талаар:

2016 оны гүйцэтгэлээр 46.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 1.22 төгрөг гарсан. Үүнээс 9 үйлдвэрийн газар 925.6 сая төгрөгийн цэвэр ашигтай, 13 үйлдвэрийн газар 47,581.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Өнгөрсөн 2017 оны гүйцэтгэлээр 17.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 1.12 төгрөг гарсан. Үүнээс 13 үйлдвэрийн газар 1,230.7 сая төгрөгийн цэвэр ашигтай, 12 үйлдвэрийн газар 20,234.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ 2018 онд дэвшүүлж буй зорилтоор 29.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн нь дараахь хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- ✓ Холбогдох зохицуулах хороод үнэ тарифын дагуу нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг Ус сувгийн удирдах газар 18.0 тэрбум төгрөг, Зорчигч тээврийн нэгтгэл 5.3 тэрбум төгрөг, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 4.5 тэрбум төгрөг, Хэсэгчилсэн инженерийн удирдах газар 507.8 сая төгрөгийн
- ✓ Нийтийн эзэмшлийн хөрөнгө бүртгэлтэй байдгаас элэгдлийн зардлаар Геодези, усны барилга байгууламжийн газар 1,607.2 сая төгрөгийн
- ✓ Бусад зорчигч тээврийн нэгтгэл 5.4 тэрбум төгрөг, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар 507.8 сая төгрөг, Нийслэлийн Төр захиргааны авто бааз 218.0 сая төгрөг, Үртсэн шахмал түлшний үйлдвэр 115.1 сая төгрөгийн алдагдал тус тус хүлээж байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын орлого, зардал, ашиг алдагдал:

/мян.төг/

№	Үзүүлэлт	2016 он	2017 он		2018 он
		гүйцэтгэл	зорилт	гүйцэтгэл	Зорилт
1	Нийт орлого	208,024,177.0	241,751,372.1	240,610,651.9	244,883,437.6
2	Нийт зардал	254,679,678.4	271,212,695.5	258,111,438.8	273,959,909.4
3	Нийт ашиг/алдагдал	-46,655,501.4	-29,461,323.4	-17,500,786.9	-29,076,471.80
	Борлуулалтын 1 төг. ногдох зардал	1.22	1.12	1.07	1.12

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

3.1.2. НӨҮГ болон оролцоотой компанийн ТУЗ, УЗ-д нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх:

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн дараах 4 газрын 2 удаагийн хуралд холбогдох мэргэжилтнүүд оролцож саналаа тусгуулж ажиллаа. Үүнд:

- Ус сувгийн удирдах газар
- Улаанбаатар зам засвар арчлалтын газар
- Хот тохижилтын газар
- Зураг төслийн хүрээлэн

3.2. Хөрөнгийн хөдөлгөөний талаар хийж хэрэгжүүлсэн ажил:

3.2.1. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн ажлын талаар

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, буцалтгүй тусламж, гадаад дотоодын хандив бэлэглэлээр нийслэлийн өмчид шинээр бий болсон эд хөрөнгийг эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгах, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн дансны залруулга хийх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг шийдвэрлэх, нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, тайлант онд хийгдсэн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг өмчийн мэдээллийн санд бүрэн гүйцэд оруулсан эсэхийг шалгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд нийслэл хотод улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын болон дотоодын хандив, буцалтгүй тусламж, зээлийн хөрөнгөөр шинээр бий болсон **нийт 8,497.5 сая төгрөгийн** хөрөнгийг бүртгэлд тусгасан. Үүнд:

1. Барилга байгууламж 1	2,681.8 сая төгрөг
2. Тээврийн хэрэгсэл 7	957.3 сая төгрөг
3. ЭБХХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө: –	709.1 сая төгрөг
4. Шинээр бий болсон эд хөрөнгө: –	4,149.3 сая төгрөг

Нэг. Барилга байгууламж - 1 нэрийн 2,681.8 сая төгрөг

- НИТХТ-ийн 2017.01.12-ны өдрийн хурлаар:

“Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчийн бүртгэлд тусгагдаагүй байсан 49,284.9 сая төгрөгийн барилга байгууламж, 3,848.8 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 112,182.4 сая төгрөгийн автозам, замын байгууламж болох нийт 165,316.2 сая төгрөгийн эд хөрөнгө /ийг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг эзэмшигч байгууллагуудад даалгасан. Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг үүрэг болгосон албан бичгүүдийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. 2017 онд өргөн барьсан тул тайланд оруулж тооцоогүй болно/



Хоёр. Тээврийн хэрэгсэл – 957,5 сая төгрөгийн 7 тээврийн хэрэгсэл

Нийслэлийн Засаг даргын 2018.01.16-ны өдрийн А/26 дугаар захирамжаар “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-т нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн нийт 887,900.000 төгрөгийн үнэ бүхий хот тохижилтын тусгай зориулалтын 2ш тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэж, тус газрын балансад тусгуулах шийдвэр гаргуулан дээрх захирамжийн биелэлтийг хэрэгжүүлж ажиллах тухай 3/83 тоот албан бичиг явуулав.

Нийслэлийн Засаг даргын 2018.01.31-ний өдрийн А/94 дүгээр захирамжаар 69,6 сая төгрөгийн 5 тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн ЧД-ийн 5 өрхийн эрүүл мэндийн төвийн балансад тусгуулахаар шийдвэрлэсэн.

Гурав. ЭБХХХК-ын хурлын шийдвэрээр бүртгээсэн эд хөрөнгө – 709,1 сая төгрөг

Төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөндөө бүртгэх зөвшөөрөл хүссэн байгууллагуудын хүсэлтийг комиссын хурлаар хэлэлцүүлж, давхардсан тоогоор **38** байгууллагын **709,1 сая** төгрөгийн эд хөрөнгийг бүртгэх Газрын даргын тушаал батлуулсан. Үүнд:

- ✓ Баянгол дүүргийн 4 байгууллагын 58,3 сая төгрөг
- ✓ Баянзүрх дүүргийн 8 байгууллагын 79,0 сая төгрөг
- ✓ Сонгинохайрхан дүүргийн 12 байгууллагын 73,6 сая төгрөг
- ✓ Сүхбаатар дүүргийн 3 байгууллагын 7,8 сая төгрөг
- ✓ Хан-Уул дүүргийн 4 байгууллагын 50,8 сая төгрөг
- ✓ Чингэлтэй дүүргийн 3 байгууллагын 439,6 сая төгрөг

Дөрөв. Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлд авах тухай албан бичиг хүргүүлсэн байдал – 4,149.3 сая төгрөг

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, нийслэлийн Автозамын хөгжлийн газар зэрэг захиалагч байгууллага болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгөөр бий болсон шугам сүлжээ, автозам, тохижилт, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийн дагуу нийт **4,149.3 сая** төгрөгийн эд хөрөнгийг данс

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

бүртгэлдээ тусгахыг үүрэг болгосон **64** албан бичгийг өмч эзэмшигч байгууллагуудад хүргүүлсэн.

“Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон **2,228.3 сая** төгрөгийн эд хөрөнгийг бүртгэлд авсан шийдвэрийг **34** байгууллага ирүүлснийг хүлээн авч судалгаанд хамруулав.

ЭБХХХК-ын шийдвэрээр 3 байгууллагын 7,1 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд, 2 байгууллагын 21,4 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд, 3 байгууллагын 40.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлэх буюу дансны залруулга хийх 8 тушаал гарган хүргүүлсэн.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтанд орж буй барилга байгууламжийг ашиглалтанд оруулах, их засварын ажил хүлээн авах нийт **5,001.0 сая** төгрөгийн төсөвт өртөг бүхий **6** комиссын бүрэлдэхүүнд орж дүүрэг хариуцсан мэргэжилтнүүд санал, дүгнэлт өгч ажилласан.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, 2018 онд санхүүжих 366 төсөл арга хэмжээний судалгааг жагсаалтаар гаргалаа. Үүнд:

- ✓ НТХО-аар хийгдэх –32,2 тэрбум төгрөгийн 68 ажил
- ✓ Замын сангийн – 22,6 тэрбум төгрөгийн 59 ажил
- ✓ НОНХС-ийн – 8,6 тэрбум төгрөгийн 143 ажил
- ✓ УТХО-аар – 2,8 тэрбум төгрөгийн 5 ажил
- ✓ Төсвийн хуулиар – 84,3 тэрбум төгрөгийн 91 ажил байна.

3.2.2. Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн талаар

- ✓ Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй нийт 55,564,128.96 төгрөгийн өртөг бүхий 32 компьютерийг тус дүүргийн ӨЭМТ-үүдэд, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй нийт 2,979,810.946 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Үерийн хамгаалалтын системийн барилга байгууламжийг “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-т балансаас балансад шилжүүлэх шийдвэр гаргуулж хүргүүллээ.
- ✓ Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх тухай” А/81 дүгээр захирамжийн дагуу Соната-6 маркийн УНР 05-79 улсын дугаартай автомашиныг ОСНААУГ-ын балансаас Нийслэлийн Тээврийн газрын балансад шилжүүлэн данс бүртгэлд тусгуулан хүлээлгэн өгсөн.

3.2.3. Данснаас хассан хөрөнгийн талаар:

Тайлант хугацаанд **144.8 сая** төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, **496.5сая** төгрөгийн хөдлөх хөрөнгө, нийт **641.3 сая** төгрөгийн эд хөрөнгийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлүүлээд байна. Үүнд:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Барилга байгууламж:

НИТХТ-ийн 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар СХД-ийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн балансад бүртгэлтэй эрүүлжүүлэхийн байр, гаражийн барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг хэлэлцүүлж НИТХТ-ийн 15 дугаар тогтоолоор шийдвэрлүүлэв.

Хөдлөх хөрөнгө:

Нийслэлийн өмчит төсөвт байгууллага, үйлдвэрийн газруудаас ирүүлсэн ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгөө актлуулж, данснаас хасуулах хүсэлтийн дагуу эд хөрөнгийг газар дээр нь үзэн, дүгнэлт гаргаж, ЭБХХК-ын хурлаар санал хэлэлцүүлэн шийдвэрлүүлэн, 3 удаагийн хурлаар **24** байгууллагын **496,5 сая** төгрөгийн хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасах тухай Газрын даргын тушаал гарсан. Үүнд:

- ✓ Баянгол дүүргийн 1 байгууллагын 12,5 сая төгрөг
- ✓ Баянзүрх дүүргийн 6 байгууллагын 235,3 сая төгрөг
- ✓ Сонгинохайрхан дүүргийн 3 байгууллагын 31,4 сая төгрөг
- ✓ Хан-Уул дүүргийн 4 байгууллагын 144,7 сая төгрөг
- ✓ Чингэлтэй дүүргийн 9 байгууллагын 72,6 сая төгрөг
- ✓ Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 12,337 сая төгрөгийн хөрөнгийг тус тус акталж данснаас хассан байна.

Тээврийн хэрэгсэл данснаас хасах ажлын талаар:

Нийслэлийн өмчит 66 байгууллагын 171 тээврийн хэрэгслийг газар дээр нь үзэж танилцан, тэмдэглэл хөтлөн чанар байдалд дүгнэлт хийж, 149 тээврийн хэрэгслийг данснаас хасах захирамжийн төсөлд оруулж шийдвэрлүүлэх, 4 тээврийн хэрэгслийг автомашин шаардлагатай байгууллагуудад шилжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/238, А/421, А/842, А/843, А/1051 дүгээр захирамжуудаар нийт **72 байгууллагын 2,830.9 сая төгрөгийн 173 тээврийн хэрэгслийг** данснаас хасах ажлыг хийж гүйцэтгэлээ.

3.2.4. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлыг зохион байгуулах:

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар байгуулагдсан Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс 2 удаагийн хурлаар нийт 50 байгууллагын 495 нэр төрлийн эд хөрөнгийн худалдан авах, шинээр бүртгэх, балансаас балансад шилжүүлэх, данснаас дансанд шилжүүлэх, данснаас хасах зэрэг асуудлуудыг холбогдох хууль журманд нийцүүлэн хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. Үүнд:

- ✓ Хөрөнгө шинээр худалдаж авах 1 байгууллагын 803,800.0 төгрөгийн
- ✓ Хөрөнгө бүртгэх 24 байгууллагын 728,828,360.0 төгрөгийн
- ✓ Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх 2 байгууллагын 3,035,375,075.0 төгрөгийн
- ✓ Хөрөнгө данснаас дансанд шилжүүлэх 4 байгууллагын 21,851,306.0 төгрөгийн
- ✓ Хөрөнгө данснаас хасах 20 байгууллагын 321,778,255.0 төгрөгийн хөрөнгө

Нийт **4,108,636,788.5** /дөрвөн тэрбум нэг зуун найман сая зургаан зуун гучин зургаан мянга долоон зуун наян найман/ мянган төгрөгийн хөрөнгийн асуудлыг хэлэлцүүлэн зөвшөөрөл олгохоор шийдвэрлэв.

3.2.5. Нийслэлийн өмчийн мэдээллийн сангийн баяжилтын талаар:

Төрийн өмчийн бүртгэлийн шинэчилсэн “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-д нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой 766 байгууллагын 2017 оны тайланг хүлээн авч нэгтгэсэн бөгөөд нийслэлийн өмч 2017 оны жилийн эцсийн балансаар нийт **2,122,457.4 сая төгрөгийн хөрөнгөтэй**, үүнээс эргэлтийн бус хөрөнгө **1,668,455.2 сая** төгрөг, эргэлтийн хөрөнгө **454,002.2 сая** төгрөг байна.

Үндэсний Статистикийн газарт гаргаж өгөх 766 байгууллагын хөрөнгийн тайлан мэдээг батлагдсан ТӨ болон ТӨХ маягтын дагуу боловсруулж, ТӨБЗГ-аар дамжуулан хүргүүлсэн.

ТӨ-1 – Дуусаагүй барилга байгууламжийн мэдээ – 12.752,4 сая төгрөг

ТӨ-2 – Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайлан нэмэгдсэн –496.028,8 сая төгрөг, хасагдсан – 232.330,1 сая төгрөг

ТӨ-3 – Биет бус хөрөнгийн бүртгэлийн мэдээ – 42.094,3 сая төгрөг

ТӨ-5 – Үнэт зүйлсийн мэдээ – 501,3 сая төгрөг

ТӨ-13.1 – Улсын чанартай авто замын мэдээ – 158.456,1 сая төгрөг

ТӨ-13.2 – Улсын чанартай гүүрийн мэдээ – 19.337,3 сая төгрөгийн нэгтгэлийг гарган ТӨБЗГ-т хүргүүлээд байна.

3.2.6. Өмч хувьчлалын ажлын талаар:

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/225 дугаар захирамжаар хувьчлагдах 8 барилга, байгууламжийг хариуцан ажиллах Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон.

Нийслэлийн өмчөөс 2018 онд хувьчлагдах 1 аж ахуйн нэгж, 7 барилга байгууламжийг хувьчлах анхны үнийг тогтоох зорилгоор мэргэжлийн үнэлгээний байгууллагуудтай гэрээ байгуулан 7 барилга байгууламжийн үнэлгээний тайланг хүлээн аваад байна.

Тус 2018 онд хувьчлагдах зарим барилга байгууламжуудын эзэмшил газрыг баталгаажуулахаар мэргэжлийн байгууллагаар кадастрын зураг хийлгэн Нийслэлийн Газрын албанд хүсэлтээ хүргүүлсэн.

Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэгийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийлгэхээр “Итгэлт эс ти мэйт” ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр 05/2017 тоот Хөрөнгийн үнэлгээ хийлгэх гэрээг байгуулсан бөгөөд тус компани нь одоогийн байдлаар үнэлгээний тайлангаа ирүүлээгүй байна.

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлаар 8 асуудал хэлэлцүүлэхээр тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүнд:

- Шинээр хувьчлах тухай – 4
 - ✓ Баянгол дүүргийн 10 дугаар хорооны хуучин барилга
 - ✓ Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны хуучин барилга
 - ✓ Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны хуучин барилга
 - ✓ Хан-Уул дүүргийн 6 дугаар хороонд байрлах Цагдаагийн түр саатуулах байрлаж буй барилга
- Өмчлөгчийн эрх олгох тухай – 1
 - ✓ “Усан спорт сургалтын төв” НӨҮГ
- Хувьчлалын тайлан батлах тухай – 3

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

- ✓ Нийслэлийн Өмчийн харилцааны газрын барилга
- ✓ Баянгол дүүргийн 19 дүгээр хорооны “Шар дэгд” Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга
- ✓ “Монгол шуудан” ТӨХК-ийн 49 дүгээр салбарын түрээсэлж байгаа байр

Барилга байгууламжийн дуудлага худалдааны талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 32/29 дүгээр тогтоолоор Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Усан спорт сургалтын төв” НӨҮГ-ыг нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлахаар шийдвэрлэсний дагуу нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2017 оны 26 дугаар тогтоолоор тус барилгын худалдах доод үнийг **8 692 000 000** /найман тэрбум зургаан зуун ерэн хоёр сая/ төгрөгөөр тогтоож, дуудлагын худалдааг зохион байгуулахыг нийслэлийн Өмчийн харилцааны газарт даалгасан.

Нээлттэй дуудлагын худалдааны зарыг 2017.12.20-ны өдрийн “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Үндэсний шуудан”, “Монголын үнэн” өдөр тутмын сонинууд, Өмчийн харилцааны газрын “Umch.ub.gov.mn” сайтад нийтэд зарласны дагуу дуудлагын худалдааг 2018.01.04-ний өдрийн 11⁰⁰ цагт нийслэлийн Төр захиргааны 5 дугаар байрны Иргэний танхимд зохион байгууллаа.

Дуудлагын худалдаанд 2 иргэн, аж ахуйн нэгж оролцохоор хүсэлт ирүүлсэн бөгөөд “Этүгэн их сургууль” ХХК нь Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Усан спорт сургалтын төв” НӨҮГ-ыг 8,702,000.000 /найман тэрбум долоон зуун хоёр сая/ төгрөгөөр худалдан авах эрхтэй болсон.

“Этүгэн их сургууль” ХХК-тай 2018.01.18-ны өдөр 01/2018 дугаартай “Худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулан “Усан спорт сургалтын төв” НӨҮГ-ыг 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр хүлээлгэн өгч акт үйлдсэн.

Шинэ өмчлөгч “Этүгэн их сургууль” ХХК-д хувьчилж авсан “Усан спорт сургалтын төв” НӨҮГ-ын өмчлөх эрхийг шилжүүлэхээр Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ олгох тухай тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэн нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.



Тээврийн хэрэслийн дуудлага худалдааны талаар:

НӨХГ-ын даргын 2017 оны А/240 дүгээр тушаалаар Нийслэлийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй,

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

сэргээн засварлаж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон тээврийн хэрэгслүүдийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан.

Тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдааг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулан давхардсан тоогоор 32 байгууллагын 33 тээврийн хэрэгслийг худалдан борлуулж **26 736 000** төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.

Менежментийн гэрээтэй байгууллагуудын талаар:

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй, ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллаж буй 20 нийтийн бие засах газар /Сити тойлет/-ыг менежментийн гэрээгээр ажиллуулахаар журам, гэрээний төслийг боловсруулан танилцуулсан.

Мөн Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг цаашид менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах журам, гэрээний төслийг боловсруулан байгууллагын удирдлагад танилцуулан, НИТХ-д өргөн барихаар бэлдээд байна.

3.3.Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн талаар:

Байгууллагын 2018 оны санхүүжилт болох орон нутгийн төсвөөс **1,061,915.5 сая** төгрөг, жилийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх **449,869.0 сая** төгрөг, нийт **1,511,780.5 сая** төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас зардлын сар, улирлын хуваарийг Нийслэлийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээр батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 01-ний дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлэн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар санхүүжилт 302,472,000 төгрөг, урсгал зардалд 274,898,395.5 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2017 оны жилийн эцсийн тайлан балансыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хуулийн хугацаанд гаргаж “Нийслэл дэх Төрийн Аудит”-аар хянан баталгаажуулж, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Мөн 2017 оны хөрөнгийн хөдөлгөөний тайланг холбогдох мэдээллийн санд шивж оруулан Төрийн өмчийн хорооны батлагдсан маягтын дагуу хугацаанд нь гаргаж, холбогдох хэлтэст хүргүүлэн тайлан мэдээнд бүрэн тусгуулсан.

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Төсөвт төвлөрүүлэх орлого төрөл	Нэгдүгээр улирлын байлдаар			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Түрээсийн орлого	350,000.0	377,818.9	108%	-27,818.9
2	Өмч хувьчлал	-	8,702,000.0	-	-8,702,000.0
3	Ногдол ашиг	-	-	-	-
4	Актлагдсан хөрөнгө борлуулсны болон автомашины дуудлага худалдааны орлого	6,000.0	29,391.5	-	-23,391.5
Дүн		356,000.0	9,109,210.4	-	-8,753.210.4

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР



Төсвийн ил тод байдлын талаар:

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу мэдээллийг цаг тухай бүр мэдээлэн ажиллаж байна. Үүнд:

6.4.5. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ –

**36 ш
8,697,023,177.00
төгрөг**

6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ –

**27 ш
8,992,281,018.00
төгрөг**

6.4.8 Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл -

**5 /тушаал/
13,575,500.00
төгрөг**

3.3.1.Түрээсийн гэрээ байгуулах, орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд:

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр хуваарь гарган Нийслэлийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээр батлуулж нэгдүгээр улирлын байдлаар 350,000.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээс 377,818.9 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэн төлөвлөгөөг 108% биелүүлэн, дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

- ✓ Нийслэлийн Соёлийн Төв Өргөөний түрээслэгч 9 байгууллагын 422,2 сая төгрөгийн үнийн дүн бүхий түрээсийн гэрээг хянан удирдлагаар батлуулсан.
- ✓ Дам болон шууд түрээсийн 186,4 сая төгрөгийн үнийн дүн бүхий 31 гэрээг хянан бүртгэн коджуулсан.
- ✓ 2017 оны жилийн эцэст үүссэн авлагаас 17,3 сая төгрөгийн өр авлагыг барагдуулсан.
- ✓ Нийслэлийн Засаг Даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаагаар батлуулсан нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, сургуулийн цайны газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх удирдамжтай ажлын хэсгийн Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийн дэд ажлын хэсэгт ажиллан, нийслэлийн өмчит ерөнхий боловсролын 38 сургуулийн үйл ажиллагаатай танилцаж тайланг нэгтгүүлсэн.

НИТХ-ийн 2010 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн нэг метр квадрат талбайн түрээсийн төлбөрийн доод үнэ”-ийг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд түрээсийн төлбөрийн доод жишиг үнийг шинэчлэх саналын судалгааг гарган боловсруулж, НЗДТГ-ын холбогдох хэлтсүүдээс санал авч, НЗД-н Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, НИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд өргөн бариад байна.

Түрээсийн гэрээ, төлбөртэй холбоотой судалгаануудыг гарган ажиллаж байна. Үүнд:

- ✓ “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн нэг метр квадрат талбайн түрээсийн төлбөрийн доод үнэ”-ийг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд түрээсийн төлбөрийн доод жишиг үнийг шинэчлэх саналын судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.
- ✓ “Буянт-Ухаа” орон сууцны хорооллоос нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчидтай байгуулсан гурвалсан гэрээний байрны төлбөрийн 30 хувийн бүрдүүлэлтийн 3 жилийн гүйлгээг шивж хүн бүрээр тулган, тооцоо нийлж, төлбөрийн үлдэгдэл барагдуулах, судалгаа тайлан мэдээ, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболдод танилцуулав.
- ✓ Урт цагаан үйлчилгээний төвийн гэрээний түрээсийн төлбөр, ашиглалтын зардалтай холбоотой судалгаа
- ✓ КРІ-ны түрээстэй холбоотой судалгаа
- ✓ Түрээслэгч нарын салбарын судалгаа
- ✓ “Буянт-Ухаа” орон сууцны хорооллын 15 байгууллагын 30 албан хаагчийн орон сууцны төлбөр бүрдүүлэлтийн судалгаа
- ✓ Өмч эзэмшүүлэх гэрээ дүгнэх ажлын хэсэгт түрээсийн өр төлбөрийн судалгаа

3.3.2.Өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөний талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02/24 дүгээр тогтоолоор 2018 онд хувьчлагдах жагсаалтыг батлуулан, нийслэлийн төсөвт 6,0 /зургаан тэрбум/ төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдснаас нээлттэй дуудлагын худалдаагаар “Усан спорт сургалтын төв” НӨҮГ-ыг 8,702,000,000 /найман тэрбум долоон зуун хоёр сая/ төгрөгөөр худалдан нийслэлийн төсөвт төвлөрүүлж нэгдүгээр улирлын байдлаар төлөвлөгөөний биелэлт 145 хувьтай байна.

3.3.3.Акталж данснаас хассан хөрөнгийн орлогын талаар:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 оны нийт 27 тушаалаар актлагдсан хөрөнгийг татан төвлөрүүлж 2017 оны А/202-р тушаалаар байгуулагдсан үнэлгээний комисс дахин үнэлгээ хийж техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон, акталж данс бүртгэлээс хасагдсан хөрөнгийг үнэлж, худалдан борлуулж устгалын акт үйлдэн ажиллаж, нийт 29 391 500 /хорин есөн сая гурван зуун ерэн нэгэн мянга таван зуун / төгрөгийн худалдан борлуулалт хийсэн байна.

3.4.Захиалагчийн хяналт тавьж ажилласан ажлын талаар:

Нийслэлийн Засаг даргаас эрх шилжиж ирсэн дараахь худалдан авах төсөл арга хэмжээнүүдэд захиалагчийн хяналт тавих болон үнэлгээний хороонд ажилласан. Үүнд:

- ✓ Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/946 дугаар “Хөрөнгө гаргах тухай” захирамж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2018 оны №01 дүгээр Үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн НӨХГ-ын зарласан “Нийслэл, дүүргүүдийн татварын албаны ажлын хэрэгцээнд зориулан компьютер, техник хэрэгсэл нийлүүлэх” НӨХГ/201712002 75,966,000.0 /далан таван сая есөн зуун жаран зургаан мянга/ төгрөгийн өртөг бүхий тендерийн зөвлөмжийг үндэслэн Худалдах, худалдан авах гэрээг НЗДТГ-аар баталгаажуулан гэрээг байгуулсан.
- ✓ Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/978 дугаар захирамжийн дагуу “Гудамж, зам, талбайн цэвэрлэгээний тоног төхөөрөмж болох бага оврын цахилгаан механизм нийлүүлэх” нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж Үнэлгээний хорооны зөвлөмж гаргуулсан. Тендерийн оролцогч Хүлгийн дээд ХХК-иас гомдол гаргасан тул тендерийн бичиг баримтуудыг жагсаалтын дагуу Сангийн яаманд хүргүүлсэн.



- ✓ Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/81 дүгээр “Хөрөнгө оруулалтын жагсаалт батлах тухай” захирамжийн дагуу Экологбус ХХК-тай “Сургуулийн автобус төслийн хүрээнд сургуулийн автобус 3 ширхэг нийлүүлэх” НХААГ-17/0040 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдсэн 398,0 сая төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг хүүхдийн зориулалттай автобусыг

хүлээн авах ажлыг зохион байгуулж, Налайх дүүргийн 59, Сонгинохайрхан дүүргийн 74, Хан-Уул дүүргийн 59 дүгээр сургуульд хүлээлгэн өглөө.

- ✓ Ус сувгийн удирдах газраас зарласан “Эрүүл мэндийн хоргүйжүүлэх ундаа” худалдан авах, “Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх”, “Компьютер худалдан авах”, Сульфат магнийн давс нийлүүлэх, тендерийн Үнэлгээний хороонд орж ажиллан, холбогдох зөвлөмж гаргууллаа.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

- ✓ Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2017 оны А/86 дугаар тушаалаар тус газрын 2018 оны байгууллагын дотоод албан хэрэгцээнд ашиглах шатахуун худалдан авах тендерийн үнэлгээний хороонд орж ажиллав.
- ✓ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2018 оны 10 дугаар тогтоолоор “Шүд эрүү нүүрний төвийн барилга худалдан авах” ажлыг зохион байгуулах тухай шийдвэр гаргуулав.
- ✓ Ус сувгийн удирдах газарт НӨХГ-ын 2/365 тоот албан бичгээр нийт 19,05 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, шинэчлэлтийн ажил, худалдан авах хөрөнгө, бараа материал зэргийг нэр төрлөөр нь багцлан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчилэн батлах тухай” 68 дугаар тогтоолыг баримтлан зохион байгуулах зөвшөөрөл олгосон.
- ✓ Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 8/01 дүгээр тогтоолыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/719 дүгээр захирамжаар Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 1,000,000,000.0 /нэг тэрбум/ төгрөгөөр Элэг шилжүүлэн суулгахад шаардлагатай 11 багц тоног төхөөрөмжийг хүлээлцүүлэх ажлын хүрээнд хийгдсэн ХСҮТ-д тоног төхөөрөмж нийлүүлсэн “Сетунари” ХХК-ны 90,000.0 сая төгрөгийн барьцаа мөнгө болох 0,5% буюу 4,5 сая төгрөгийг чөлөөлөхөд холбогдох бичиг баримтыг бүрдүүллээ.

3.5. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаар:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу байгууллагын **65** ажилтан, албан хаагчийн хувийн хэргийг хөтлөн баяжуулалт хийж байна.

Төсвийн шууд захирагчтай байгуулах 7 нэгжийн менежер, 25 төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ, мөн 24 үйлчилгээний ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллагч 2 иргэнтэй хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулах ажлыг зохион байгууллаа.

Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны 6 албан хаагчид төрийн албан хаасны хугацааны нэмэгдлийг шинээр олгуулан ажиллалаа.

Төрийн албаны мэргэжлийн шалгалтад орж нөөцөд бүртгэгдсэн 4 иргэнийг нөөцөөс сонгох тухай хүсэлт, материалыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэн, Нийслэлийн салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэний дагуу томилгоог баталгаажууллаа.

Төрийн албан хаагч бүрийн төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажлын цаг ашиглалтыг мөрдөн ажиллахад хяналт тавьж, эмнэлгийн чөлөөтэй 7 /листээр/, захиргааны чөлөөтэй 4, газрын даргын тушаалаар 1 албан хаагчийн чөлөө олгох бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөн ажиллаж байна.

Ажилтан, албан хаагчдын 2018 оны ээлжийн амралтын хуваарийг албан хаагчдын санал, ажлын ачаалал, шаардлагад нийцүүлэн хийж газрын даргын 2018 оны Б/16 дугаар тушаалаар батлуулан ээлжийн амралтын мэдэгдлийг гарган ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолын дагуу албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 03 дугаар сарын 29-ний өдөр хүртэлх хугацаанд НӨХГ-ын хүний нөөцтэй холбоотой 16 тушаал батлуулсан байна.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

№	Тушаалын нэр	Тоо	Биелэлт
1	Ажилд шинээр томилох тухай	7	100%
2	Чөлөө олгох тухай	1	100%
3	Тэтгэмж, тусламж олгох тухай	1	100%
4	Зардал гаргах тухай	1	100%
5	Сэлгэн ажиллуулах тухай	1	100%
6	Бүтэц өөрчлөлт оруулах тухай	1	100%
7	Ээлжийн амралтын хуваарь батлах тухай	1	100%
8	Бусад	3	100%
	Нийт	16	100%

3.5.1. “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, /Сургалт семинар, нийгмийн баталгаа/

Албан хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зорилгоор байгууллагын 2018 оны сургалтын төлөвлөгөө болон мэдээллийн цагийн хуваарийг батлуулан хуваарийн дагуу зохион байгуулж ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

Газрын даргын баталсан сургалтын болон мэдээллийн цагийн хуваарийн дагуу:

- ✓ Удирдлагын Академын багш н.Мөнхбаяр 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” сэдэвт сургалтыг нийт хэлтсийн дарга, хариуцсан мэргэжилтнүүдэд
- ✓ “Хөтөч гэрэл” ТББ-ын сургагч багш М. Жаргалант 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдөр “Хувь хүний хөгжлийн 3 тулгуур” сэдэвт сургалтыг нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан.



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Харьяа, дээд байгууллагаас зохион байгуулагдсан сургалтууд:

- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах, орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг 2018 онд зохион байгуулахтай холбогдуулан Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газраас 2018 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд “Хөрөнгийн дахин үнэлгээний бэлтгэл, 2018 оны улсын нэгтгэлд анхаарах асуудлууд”, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системийн танилцуулга” сургалтад холбогдох албан тушаалтан, албан хаагчид
- ✓ НЗДТГ-аас зохион байгуулсан ХАСХОМ-ийг бүртгэх хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтад Захиргаа, санхүүгийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Н.Золжаргал
- ✓ НЗДТГ-аас зохион байгуулсан “LOGIN”-ийн сургалт, “Хувь хүний хөгжил-Сэтгэлгээний 6 малгай” сэдэвт сургалтад захиргаа, санхүүгийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Н.Золжаргал
- ✓ Нийслэлийн Өмчийн харилцааны газар, орон нутгийн өмчийн газрын хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн тулган баталгаажуулалт хийх хуваарь болон семинарыг 2018 оны 03 дугаар сарын 12-ноос 16-ны өдрүүдэд зохион байгуулан холбогдох албан тушаалтнууд
- ✓ НЗДТГ-аас зохион байгуулсан “Нийслэлийн төр хувийн хэвшлийн түншлэл” сэдэвт сургалтад ӨТМХХ-ийн албан хаагчид
- ✓ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 20178 оны А/605 захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгээс Нийслэлийн шилэн төндэрийн open.ulaanbaatar.mn системийн сургалтад Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн Ч.Чулуунтөгс, нягтлан бодогч Т.Оюунтуул нар
- ✓ Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан “Монгол Улсын Төрийн гадаад, дотоод бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах нь” сэдэвт сургалтад Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Х.Жаргалсайхан, мэргэжилтэн П.Түвшинжаргал нар оролцсон.
- ✓ Нийслэлийн Архивын газраас архив албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр “Алсын зайны сургалт” –д 2018 оны 03 сарын 28-ны өдрийн 09:00-10:00 цагт нийт албан хаагчид онлайн сургалтад хамрагдлаа.





- ✓ Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллэх дохиогоор ажиллах дадлага сургуулилтад 2018.03.29-ний өдрийн 16:00 цагт нийт албан хаагчид дохион дуугаар Сүхбаатарын талбайд цугларч, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх ажиллагаанд оролцлоо.

Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах талаар:


Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст байгууллагын төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын нэрсийг жагсаалтыг хүргүүлж, хуулийн үйлчлэлд хамаарах ТЗ-6-аас дээш ангиллын 12 албан хаагчдаас 2017 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг, шинэчлэн томилогдсон 1 албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч дуусган дүн мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлж, 1 албан тушаалтны хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулсан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ” БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ”

4.1. Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай болгох стратегийн зорилтын хүрээнд:

Нийслэлийн өмч харилцааны талаарх мэдээ мэдээллийг түгээх, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээ мэдээлэл хүргэх, үйл ажиллагааг зохицуулах зорилго бүхий “Нийслэлийн Өмчийн харилцааны газрын цахим хуудасны үйл ажиллагааны журам”-ыг байгууллагын цахим хуудасны үйл ажиллагаанд мөрдлөг болгон үндсэн үйл ажиллагаатай холбоотой болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдаж буй ажлуудын талаарх мэдээллийг байршуулан ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР



Байгууллагын веб-сайтад олон нийтэд нээлттэй ил тодоор дараах мэдээллүүдийг байршуулсан.

- ✓ Байгууллагын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан цахим хуудасны мэдээллийг шинэчлэн засварласан. Үүнд:
 1. Утасны жагсаалт
 2. Хэлтсүүдийн ажил үүргийн хуваарь, бүтэц
 3. Албан хаагчдын цахим хаягийн мэдээлэл
- ✓ Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллүүдийг тухай бүр шинэчлэн байршуулж байна. Үүнд :
 1. Тээврийн хэрэгсэл болон барилга байгууламжийн нээлттэй дуудлагын худалдааны зар
 2. Томуугийн вакцинд хамрагдсан тухай
 3. “Цасны баяр” спорт арга хэмжээ
 4. Туршлага солилцох уулзалт /Орон нутгийн өмчийн газруудын албан хаагчидтай/
 5. Нийслэлийн өмчийн барилга байгууламжийн нэгж талбайн түрээсийн төлбөрийн доод жишиг үнийг тогтоох тухай сонсох үйл ажиллагааны тухай мэдээлэл
 6. Бусад сургалт семинаруудын талаарх мэдээлэл

4.2. Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын талаар:

Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Нийслэлийн Засаг даргын орлогч дарга Ш.Анхмаагийн 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 09-ний өдөр хүртэл Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2017-2018 оны хичээлийн жилийн “Үдийн цай” хөтөлбөр, цайны газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчилж байгаа эсэх болон бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд шинжилгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч санал, дүгнэлт гаргах ажлын хэсэгт ажиллалаа.

Хамтран ажилласан байгууллага:

- Дүүргийн мэргэжлийн хяналтын газар
- Дүүргийн Боловсролын газар

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

- Дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс
- Хоол зүй, шим судлалын Монголын нийгэмлэг

Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан дүүргүүдэд ажлын хэсэг нийслэлийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжүүлдэг ААН-н үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт хийж цайны газрын түрээслэгчийн гэрээний биелэлтийг бодит байдал дээр үзэж танилцлаа.

Ажлын хэсэг нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цайны газрын түрээслэгчийн гэрээний биелэлтийг бодит байдал дээр үзэж танилцан холбогдох судалгаа дүгнэлтийг гарган ажиллалаа.

4.3. Хууль шүүхийн байгууллагад төлөөлөх ажлын талаар:

Тайланд хугацаанд анхан шатны шүүхэд хянагдаж байгаа 7, давж заалдах, хяналтын шатны шүүх дээр маргаантай асуудлууд хянан шалгагдаж байна. Үүнд:

- ✓ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлыг төлөөлж 3
- ✓ Нийслэлийн Засаг даргыг төлөөлж 2
- ✓ Нийслэлийн Өмчийн харилцааны газрыг төлөөлж 4 хэрэгт хариуцагчаар оролцсон.



Нийт хэргийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр 4, Иргэний хэргийн анхан шатны шүүхээр 1 хэрэг, Давж заалдах шатны шүүхээр 2 хэрэг хянагдаж байна.

Шүүхийн анхан шатанд хянагдаж байгаа хэргийн мэдээний талаар:

1. Нэхэмжлэгч: “Анома” ХХК
Хариуцагч: НИТХ, НӨХГ
Нэхэмжлэлийн утга: 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын асуудал
Тайлбар: ЧД-ийн ИХАШ шүүхэд хянагдаж байгаа
2. Нэхэмжлэгч: “Хар чоно” ХХК
Хариуцагч: НИТХ, НЗД
Нэхэмжлэлийн утга: Хувьчлалын тухай
Тайлбар: НЗХАШ шүүхэд хянагдаж байна.
3. Нэхэмжлэгч: “Жи Эй Би Өү Ти” ХХК
Хариуцагч: НИТХ
Гуравдагч этгээд: ОСНААУГ
Нэхэмжлэлийн утга: “Буянт- Ухаа” 1,2 дугаар хорооны УДДТөв-д холбогдох НИТХ-ын 2016 оны 25 дугаар тогтоол хэрэгсэхгүй болгох тухай
Тайлбар: НЗХАШ шүүхэд хянагдаж байна.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

4. Нэхэмжлэгч: Зорчигч тээврийн нэгтгэл-ийн ҮЭ хороо
Хариуцагч: НЗД
Нэхэмжлэлийн утга: НИТХ-ын 2018 оны 24/05, НӨХК-ын 16 дугаар тогтоолуудыг хүчингүй болгох
Тайлбар: НЗХАШ шүүхэд хянагдаж байна.

Хяналтын шатны шүүхээр хянагдаж байгаа хэргийн талаар:

1. Нэхэмжлэгч: “Ган хийц” ХХК
Хариуцагч: НӨХГ
Нэхэмжлэлийн утга: 13 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын тухай
Тайлбар: СХД-ийн шүүх, 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 00202 шийдвэрээр, Нийслэлийн ДЗШШ-ээс 2018 оны 03 дугаар сарын 19-нд шийдвэрт өөрчлөлт оруулж 13 сая төгрөгийг СХД-ийн ЗДТГ-аас гаргахаар шийдвэрлэсэн.

Давж заалдах шатанд хянагдаж буй асуудлуудын талаар

1. Нэхэмжлэгч: Иргэн Уранзаяа
Хариуцагч: НӨХГ
Нэхэмжлэлийн утга: 5,344,062 төгрөгийг нэхэмжилсэн
Тайлбар: ЧД-ийн ИХАШШ-ын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдөр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.
Нэхэмжлэгч: иргэн М.Отгонжаргал
Хариуцагч: НӨХГ, НГА
Нэхэмжлэлийн утга: 9,177.205 төгрөгийг нэхэмжилсэн /Ажилд эгүүлэн тогтоох/
Тайлбар: НЗХАШШ-ын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 0093 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийг ханган 9.1 сая төгрөгийг олгож, ажилд нь эгүүлэн тогтоохыг НГА-д даалгасан.

ТАВДУГААР БҮЛЭГ. “БУСАД МЭДЭЭЛЭЛ”

5.1. Нийслэлийн төсөвт байгууллагууд, НӨҮГ-ууд болон бусад байгууллагуудад хийж хэрэгжүүлсэн ажил

- ✓ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын баталсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, Улаанбаатар хотын захирагчийн харьяа газруудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын удирдамжийн дагуу 2018 оны 01 дүгээр сарын 10-наас 19-ний өдрүүдэд шалган зааварлах ажлын хэсэгт холбогдох мэргэжилтнүүд ажиллан Захирагчийн харьяа аж ахуйн тооцоот 20 байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт хамгаалалт, Контрактын биелэлттэй танилцаж, үнэлэлт өгч ажиллаа.
- ✓ Нийслэлийн Засаг даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2017 оны А/772 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2018 оны 2 дугаар сарын 21-26-ны өдрүүдэд “Зорчигч Тээврийн Нэгтгэл” ОНӨААТҮГын 2016, 2017 онд Хөдөлмөрийн гэрээ цуцлагдан халагдсан ажилтан албан хаагчдад олгосон тэтгэмж, өндөр настны тэтгэмж авахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан ажиллагсдад шүүхийн шийдвэрийн дагуу тэтгэмж олгосон болон 2017 оны

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Контрактын биелэлттэй танилцаж шалгалаа. Тус ажлын хэсэг 4 удаа хуралдсан бөгөөд илтгэх хуудас, дүгнэлт боловсруулан ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.

- ✓ “Дун-Өргөө” ХХК-ийн захирал н.Буяннэмэхтэй 2 удаа уулзаж, тус байгууллагын үйл ажиллагаа цаашид авах арга хэмжээний талаар саналаа солилцож газрын даргад танилцуулсан. Нийслэлийн Засаг даргын 2007 оны “Нийслэлийн өмчийн оролцоотой хамтарсан компани байгуулах тухай” 555 дугаар захирамжийн дагуу “Хар дун” ХХК-ийн 75 хувьд ногдох хөрөнгө оруулалтыг баталгаажуулж, үнэлгээ хийлгэх шаардлагатай талаар албан бичиг хүргүүлэв.
- ✓ Татан буугдсан “Ионсей найрамдал эмнэлэг” ХХК-ны Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст төлөх үлдэгдэл төлбөр **4,431.045** сая төгрөгийг төвлөрүүлэн, өр төлбөргүй талаар албан бичиг авч тус дүүргийн Татварын хэлтэстэй тооцоо нийлж, өр төлбөргүй талаар албан бичиг авахаар болсон.
- ✓ Татан буугдсан “Уламжлалт эм эмийн ургамал компани” ОНӨААТҮГ-ын хаалтын баланс гарган Баянзүрх дүүргийн Төрийн сангаар баталгаажуулах, тус үйлдвэрийн газрыг бүртгэлээс хасуулах үүднээс дүүргийн Татварын хэлтэст Үл хөдлөх хөрөнгийг бүртгэлээс хасуулах, Хяналт шалгалтын актуудаар ногдуулсан хүү торгуулийн алдангийг “Өршөөлийн хууль”-д хамруулах талаар 2/308, 2/309, 2/310 тоот албан бичиг хүргүүлж, төлбөр тооцоогүй талаар албан бичиг авахаар хүлээгдэж байна.
- ✓ Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/220 дугаар Багахангай мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-н үйл ажиллагаанд үүссэн нөхцөл байдалтай танилцан, үнэлэлт дүгнэл өгөх, цаашид шийдвэрлэх санал боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Налайхын шийдвэр гүйцэтгэх хэсгээс Улаанбаатар хотын банкны зээлийн барьцаанд хураан авсан үйлдвэрийн талаар болон шүүхийн шийдвэрийн талаар танилцуулга бэлтгэн, холбогдох материалын хамт Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.
- ✓ Хувийн хөрөнгө оруулалттай Олонлог бүрэн дунд сургуулиас ирүүлсэн хүсэлтийн дагуу Чингэлтэй дүүргийн 24 дүгээр сургуулийн барилга, газар эзэмшилт, биеийн тамирын талбай, номын сангийн талаар судлан, танилцуулга бичиж хүргүүлсэн.
- ✓ Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-аас ирүүлсэн Зайсан толгой дахь нийтийн эзэмшлийн зам талбайд байрлах төлбөртэй зогсоолын барилгыг “СОБТ трейд” ХХК-д шилжүүлэх хүсэлтийг судлан үзэж, Зөвлөлтийн дайчдад зориулсан дурсгалын хөшөө цогцолбор нь НИТХТ-ийн 2007 оны 197 дугаар тогтоолоор түүх соёлын дурсгалт зүйлийн жагсаалтанд багтсан тул НӨХГ-ын 2018 оны 2/297 тоот албан бичгээр холбогдох мэргэжлийн байгууллагуудаас зөвшөөрөл авахыг мэдэгдсэн.
- ✓ Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй ундны усны дээд эх үүсвэрт байрлах уурын зуухийг Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газарт шилжүүлэх боломжтой эсэх талаар газар дээр нь танилцуулах ажлыг зохион байгуулсан.
- ✓ “УБ хотын даатгал” ХХК-ны хувьцаа худалдах санал ирүүлснийг мөн тус байгууллагад Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 3/773 тоот албан бичгээр Даатгалын компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 5.0 тэрбум төгрөгт хүргэх төлөвлөгөө, тайлбарыг 2018 оны 03 дугаар сарын 15-ны дотор ирүүлэх шаардлага ирүүлсэн байна. Энэхүү тогтоолын хүрээнд компаниас шинээр гаргах хувьцааг Нийслэлийн Өмчийн харилцааны газраас худалдан авч, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувиа нэмэгдүүлэх талаар санал ирүүлсэн бөгөөд удирдлагуудад тус саналыг байгууллагын талаарх танилцуулгын хамт боловсруулан танилцуулсан.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

- ✓ Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын талбайд “Худалдаа, үйлчилгээ эрхлэх журам”-ыг шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон тул журмын төсөлтэй танилцан саналаа хүргүүлэв.
- ✓ “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг шинэчлэн найруулж, боловсруулан байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.
- ✓ НИТХТ-ийн 2017 оны 123 дугаар тогтоол, НЗД-ын 2017 оны А/865 дугаар “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” захирамжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий НӨХГ-ын даргын 2017 оны А/781 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн сүүлийн хурлыг 2018.02.07-ны өдөр хуралдуулж, ОСНААУГ-т БЗД-ийн 4 дүгээр хорооны Нарны замын 81-р байр, ХУД-ийн 11 дүгээр хорооны 85А, Б байр, БГД-ийн 7 дугаар хороо, Пром-36 байр гэсэн 4 байрны шугам сүлжээ, БЗД-ийн 13 дугаар хороо, 116 дугаар байрны үнийн дүнгийн зөрүү, давхардаж орсон БЗД-ийн 2 дугаар хорооны 64/2 байрны нийт 373,548,932.0 төгрөгийн хөрөнгийг хасч, **5,340,805.0** төгрөгийн хөрөнгө хүлээн авсан акт ирүүлэхийг шийдвэрлэсэн.
- ✓ НИТХТ-ийн 2017 оны 125 дугаар тогтоол, НЗД-ын 2017 оны А/864 дүгээр “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” захирамжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий НЗД-ын 2017 оны А/953 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хурлыг 2018.01.24-ний өдөр хуралдуулан захиалагч, гүйцэтгэгч, эзэмшигч байгууллагуудын инженерүүдтэй хамтарч нийт инженерийн байгууламжийн чанар байдлын талаар дүгнэлт гаргасан. Үүнд:
 - Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооллын 1 573 197 391 төгрөгийн өртөг бүхий Ус дулаан дамжуулах 6 төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ОСНААУГ-т
 - Сонгинохайрхан дүүргийн Ханын материал орчмын 800 499 364 төгрөгийн өртөг бүхий Ус дулаан дамжуулах төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-т
 - Хан-Уул дүүргийн Яармаг хорооллын 2 703 422 000 төгрөгийн өртөг бүхий бохир усны шугам, насос станцын барилга байгууламжийг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-т
 - Мөн Сонгинохайрхан дүүргийн Баянголын амны Ус дулаан дамжуулах 1 төвийн барилга, тоног төхөөрөмжийг ОСНААУГ-т хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэсэн.

ЗУРАВДУГААР БҮЛЭГ.

1. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛУУД:

6.1.1.Иргэдийн өргөдөл, санал гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой мэдээлэл:

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын А/119 дүгээр захирамжаар байгууллагын бүтэц орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Өргөдөл, гомдлын нэгдсэн систем Smartcity.mn-д албан хаагчдын нэвтрэх нэр болон мэдээллийг шинэчлэн оруулсан.

Тайлант хугацаанд байгууллагад нийт **14** өргөдөл хүлээн авснаас хугацаандаа шийдвэрлэсэн **13**, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 1 өргөдөл байгаа бөгөөд өргөдөл, хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл **13** хүсэлт, **1** гомдол байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт **100%**, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 20 цаг байна.

Тайлант хугацаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдтой уулзах хүсэлт 3 ирж холбогдох мэдээлэл, танилцуулгыг бэлтгэн хүргүүлсэн.


НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

6.1.2.Ирсэн бичгийн бүртгэл, хяналтын ажлын талаар:

Нийслэлийн Өмчийн харилцааны газарт 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар EDOC программд нийт 771 албан бичиг бүртгэгдснээс Захиргаа, санхүүгийн хэлтэст 151, Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэст 422, Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын хэлтэст 157, Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст 40 албан бичиг ирж бүртгэгдсэн байна.

Шийдвэрлэлт						
№	Хэлтэс	Шийдвэрлэгдсэн	Судлагдаж байгаа	Хугацаа хэтэрсэн	Нийт	хувь
1	Захиргаа, санхүүгийн хэлтэс	146	7	-	153	95%
2	Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс	358	63	-	421	98,8%
3	Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын хэлтэс	139	18	-	157	98,6%
4	Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс	39	1	-	40	99,2%
5	Нийт	682	89	-	771	97,9%

Ирсэн албан бичгийг графикаар үзүүлвэл:



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

6.1.3. Архивын хөтлөлтийн талаар:

Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн архивын баримт материал, хадгаламжийн нэгжүүдийн эмх цэгцийг ханган ажиллах ажлын хүрээнд архивын ажлын үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулахад бэлэн болгоод байна.

№	Баримтын төрөл	ББаримтын хязгаар	ББаримтын тоо	Тайлбар
11	Байнга хадгалах хадгаламжийн нэгж	22004- 2016	22757 ХН	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой баримтууд
22	Түр хадгалах хадгаламжийн нэгж	1999-2016	11925 ХН	Ирсэн, явсан бичиг, харилцахын баримт
33	70 жил хадгалах хадгаламжийн нэгж	11991-2016	890 ХН	Газрын даргын “Б” тушаал, санхүүгийн баримт /нийгмийн даатгал/
44	Тусгай төрлийн баримт	22009-2014	5 11ХН	CD, зураг
5	Нийт	1991-2016	4783 ХН	Хадгаламжийн нэгж

Архивын сан хөмрөгөөс энэ оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 62 баримтын лавлагаа мэдээллийг гарган хуулбар үнэн тамга дарж баталгаажуулсан.

6.1.4. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын тушаалын биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд газрын даргын нийт 97 тушаал гарснаас “А” буюу хөрөнгө бүртгэн авах, балансаас балансад шилжүүлэх, данснаас дансанд шилжүүлэх, данснаас хасах зэрэг үндсэн чиг үүргийн дагуу 81 тушаал, “Б” буюу хүний нөөцийн чиглэлээр 16 тушаал гаргаж 100%-ийн биелэлттэй байна.

№	Тушаалын нэр	Тоо	Биелэлт
1	Эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай	29	100%
2	Эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай	32	100%
3	Ажлын хэсэг байгуулах тухай	7	100%
4	Эргэлтийн бус хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай	2	100%
5	Эргэлтийн бус хөрөнгө данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай	5	100%
6	Спорт өдөрлөг зохион байгуулах тухай	1	100%
7	Тооллого хийх тухай	1	100%
8	Хариуцлагатай жижүүр, эргүүл томилон ажиллуулах тухай	1	100%
9	Спортын наадам цасны баярт оролцох тухай	1	100%
10	Удирдлагын зөвлөлийг шинэчлэн батлах тухай	1	100%
11	Зардал гаргах тухай	1	100%
12	“Б” хүний нөөцийн чиглэлээр	16	100%
	Нийт	97	100%

6.2. Дотоод ажлын талаар:

Туршлага солилцох уулзалт: Нийслэлийн Өмчийн харилцааны газрын үйл ажиллагаатай танилцах зорилгоор орон нутгийн өмчийн газруудын дарга, мэргэжилтнүүд 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах уулзалт хийсэн.



Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай: Билгийн тооллын хаврын тэргүүн сарын Цагаан сарын баярыг тохиолдуулан байгууллагын харьяалалд бүртгэлтэй ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, гарын бэлэг гардуулах ажлыг 2018 оны 02 дугаар сарын 09, 13-ны өдөр зохион байгуулсан.



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

“Цасны баяр” спорт арга хэмжээ: Мөнгөн Улаанбаатар спорт наадмын “Цасны баяр” арга хэмжээ 2018 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Хандгайтын Янзага зусланд зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцлоо.



Томуугийн вакцин хамрагдсан: Нийслэлийн Өмчийн харилцааны газрын албан хаагчид 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Томуугийн вакцинд хамрагдлаа.



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

НИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд өргөн барьсан асуудлууд:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчид үнэ төлбөргүйгээр шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам”-ын дагуу хувийн хэвшлийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулсан 12 орон сууцны барилгын үнэ төлбөргүй нийслэлийн өмчид шилжүүлэн өгч буй 388,6 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн эд хөрөнгө /инженерийн байгууламж/-ийг нийслэлийн өмчид бүртгэх тухай НЗДТГ-ын 2018.02.26-ны өдрийн 01/693 тоот албан бичгээр НИТХТ-ийн хуралдаанд өргөн бариад байна.
2. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод үнийг шинэчлэн батлах тухай НИТХТ-ийн хуралд өргөн барьсан.

Цаашид авах арга хэмжээ:

1. Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах
2. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын худалдан авалтын төлөвлөгөөг ил тод болгон худалдан авалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хяналтыг сайжруулах, удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулан төсвийн зардлыг хэмнэх
3. Дүүргүүдийн ОНӨҮГ-уудын эрх зүйн орчинг боловсронгуй болгож үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх асуудлыг судлан хэрэгжүүлэх
4. Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийг үнэлэх, нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийж байгууллагын дансанд тусгуулах
5. Нийслэлийн өмч хувьчлалын 2019 оны хөтөлбөр боловсруулж, шийдвэрлүүлэх
6. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд болон оролцоотой компаниудад компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх
7. Нийслэлийн өмчийн менежментийг сайжруулах бодлогын баримт бичиг" боловсруулах
8. Өмчийн харилцаатай холбоотой дүрэм, журманд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчлэн боловсруулж НИТХ-д өргөн барьж хэлэлцүүлэх
9. “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ыг өөрчлөн байгуулах тухай НИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх
10. Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төв ОНӨТҮГ-ыг татан буулган, ЗАА-тай нэгтгэх тогтоолын төсөл боловсруулах
11. Хан-уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ, Геодези, усны барилга байгууламж ОНӨААТҮГ-ын хүсэлтийн дагуу тээврийн хэрэгсэл худалдан авах НЗД-ын захирамж, танилцуулга бэлдэж, санал авах
12. “Авто худалдааны цогцолбор” ОНӨААТҮГ-ын дүрмийг судлаж, НИТХ-аар дахин хэлэлцүүлэх
13. Нийслэлийн Төр Захиргааны Автобааз” ОНӨААТҮГ-ын бүртгэлд байсан 2 автомашины балансаас балансад шилжүүлсэн асуудлыг НИТХТ-ийн хуралд өргөн барих, тогтоолын төслийг боловсруулан санал авах

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

- 14.** 2018 онд Улсын төсвийн хөрөнгөөр буюу Японы ЗГ-ын буцалтгүй тусламжаар баригдах цэцэрлэг, сургуулийн барилгыг буулгаж, шинээр барих ажлын хүрээнд хөрөнгө данснаас хасах танилцуулга, тогтоолын төсөл боловсруулах, санал авах
- 15.** Монгол улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн, Сонгинохайрхан дүүргийн 2, 3, 4, 19, 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан 3.6 км хатуу хучилттай, 48.7 урт/м, 36.7 урт/м төмөр бетон хүчин чадал бүхий, зам гүүрийн зориулалттай барилга байгууламжийн ажлийг НИТХТ-д өргөн барих тогтоолын төслийн танилцуулгад санал авах
- 16.** УИХ-ын гишүүн Ж.Ганбаатарын хувийн хөрөнгө оруулалтаар барьсан БГД-ийн 9, 10-р хорооны нутаг дэвсгэрт орших 1.0 км авто замыг нийслэлийн өмчид бүртгүүлэх НИТХ-ын тогтоолын төсөлд санал авах

Тайлантай танилцсан:

Ч.Однасан /НӨХГ-ын дарга/

Хянасан:

Х.Жаргалсайхан /Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга/

Тайлан нэгтгэсэн:

Ц.Цолмон /ЗСХ-ийн мэргэжилтэн/

Хяналт, шинжилгээ,

үнэлгээ хийсэн:

Ж.Сувданзаяа /ХШҮХ-ийн мэргэжилтэн/